



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 5/51

Хэрлэн сум

Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 38 дугаар зүйлийн 38.1, 38.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн эрхлэгч С.Оюунгэрэлийн өөрийн гаргасан хүсэлтийг үндэслэн 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн цэцэрлэгийн эрхлэгчийн хөдөлмөрийн гэрээг цуцалж, үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Цэцэрлэгийн эрхлэгчийн ажлыг хүлээлцэх комисс томилон хүлээлцүүлэхийг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т даалгасугай.

3. С.Оюунгэрэлтэй зохих хууль, журмын дагуу холбогдох тооцоо хийж дуусгахыг цэцэрлэгийн нягтлан бодогч /Н.Энхтуяа/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА